



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/70

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Инженерийн хийцтэй гүн өрөмийн худаг шинээр гаргах, засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Даваасүрэн Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга

Нарийн бичгийн дарга: - Т.Гантулга Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн


Гишүүд: -Б.Мөнхбат Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Т.Эрдэнэбаяр Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн
Ш.Авирмэд (Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн) (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100162